

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-007137, MV-004878, MV-007197, MV-010875, MV-012131 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад хаалтын болон нөхөн сэргээлтийн төсөл хийлгэх, тайланг БОАЖЯ, МХЕГ-аар хянуулан батлуулах зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Зэрэгцээ алтны үйлдвэрийн ашиглалт явуулсан MV-007137, MV-004878, MV-007197, MV-010875, MV-012131 тоот тусгай зөвшөөрөлтэй 5 талбайд компанийн хуулиар хүлээсэн үүрэг болон нийгмийн хариуцлагыг биелүүлэх хүрээнд хаалтын болон нөхөн сэргээлтийн төсөл боловсруулж Байгаль орчны тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, дүрэмд нийцүүлэн байгаль орчны болон хяналт шалгалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын зөвлөмж, зөвшөөрлийг авч батлуулах болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ,
- Нөхөн сэргээлтийн төсөл боловсруулах эрх бүхийг батлах тусгай зөвшөөрлийн хуулбар,
- Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар.

Дээрх баримтууд нь эх хувиараа байх, хэрэв хуулбар хувь бол заавал нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд бүх материалыг pdf файлын хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай харагдахаар цахимаар ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 06–ны өдрийн 17<sup>00</sup> цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 05 дугаар сарын 13–ны өдрийн 09<sup>40</sup> цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

**Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр**  
**Утас: 458401, Факс: 458380** Имэйл хаяг: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn)  
**Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар**  
**ирүүлнэ.**